# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮСНЭГТ

2021.12.15

Багахангай дүүрэг

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Үнэлгээний хувь |
|---|---|---|---|
| | Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал | | |
| 1. | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Байгууллагын эрхэм зорилго, гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 138 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан ба төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 94.2 хувьтай хэрэгжсэн байна. Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг bagakhangai.ub.gov.mn сайтын "Ил тод байдал" цэсний "Байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээ" дэд цэсэнд байршуулж ажиллав.<br>Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/121 дүгээр захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2020 оны А/44 дүгээр захирамжаар "Дүүргийн харьяа байгууллагууд, Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг батлах тухай" бүтэц орон тооны захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/09 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалт, ангилал зэрэглэлийг | 90 |
| 2 | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Өргөдөл гомдол хариуцсан ажилтаны мэдээлэл болон өргөдөл гомдол хүлээн авах цагийн хуваарийг дүүргийн сайтын Зар мэдээ, урсдаг баннер, үйл ажиллагааны ил тод байдал цэсэнд байршуулав. | 90 |
| 3. | Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | ЗДТГ-аас иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байгаа бөгөөд дараах уламт бичгийг дүүргийн вэб сайтын төрийн үйлчилгээ цэсэнд байршуулав.<br>• Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулах, батламж шинээр авах, сунгуулахад бүрдүүлэх материалын жагсаалт<br>• Архивын лавлагаа авах, олгох заавар<br>• Согтууруулах ундаа ьүүгээр үйлчлэх, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материал<br>• ЗДТГ-аас үзүүлэх Төрийн үйлчилгээний жагсаалтыг тус тус байршуулав. | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| 4. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжгой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | ЗДТГ-ын удирдлага, албан хаагчид, ААНБ, хороонуудад үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг Багахангай хэвлэл мэдээлэл, ЗДТГ-ын дотоод группт, мэдээллийн самбарт цаг тухай бүрт нь мэдээллийг хүргэж ажиллаж байна. | 90 |
| 5. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байршуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах | Дүүргийн вэб сайтад хууль, журмын төсөлд санал авах гэсэн цэс нээж 3 хуулийн төсөл байршуулж, иргэдээс санал ирээгүй байна. Шинэчилэн найруулж байгаа 7 хууль, 8 журмын төсөлд иргэдээс бичгээр ирсэн 42 саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн 38 иргэн эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл авсан байна. Эрх зүйн сурталчилгааны самбар болон дүүргийн вэб сайт, байгууллагынхаа Хэвлэл мэдээлэл facebook цахим хуудсаар дамжуулан 15 байгууллага 80 гаруй хууль, тогтоомжийг байршуулж ажилласан байна. | 90 |
| 6. | Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа, эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | 2021 тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ын судалгааг шинэчлэн гаргаж, дүүргийн вэб сайтын ил тод байдалын цэсэнд байршуулав. | 90 |
| 7. | Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх | Дүүргийн ИТХ-н 2020 оны А/09 тоот тогтоолын 1-р хавсралтад заасан Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, 2-р хавсралтад заасан орон нутгийн хөгжлийн сангийн нийт 11 ажлын худалдан авах төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Дүүргийн засаг даргаар батлуулсан.<br>Худалдан авах ажлын төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр "Өнөөдөр" сонинд нийтлэн, шилэн дансны болон холбогдох сайтуудад сар бүр байршуулан ажиллалаа.<br>Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар болон Нийслэлийн засаг даргаас эрх шилжиж ирсэн тендер шалгаруулалтанд оролцсон компаниудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан тухай мэдэгдлийг 14 байгууллагад, шалгараагүй мэдэгдлийг 14 байгууллагуудад хүргүүлсэн. Мөн tender.gov.mn, shilendans.gov.mn сайтад тухай бүр тендер шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээллийг байршуулсан. Нийслэлийн Төрийн аудитын газраас 2020 онд зохион байгуулагдсан хөрөнгө оруулалтын ажилд аудит хийсэн бөгөөд аудитын дүгнэлтийг шилэн дансанд байршуулсан. | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| Үнэлгээний дундаж хувь: | | | 90% |
| Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал | | | |
| 1. | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, ажлын хүрээнд ажлын байрны сул орон тоог нөхөх ажлын хүрээнд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан ".“Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын дагуу ТЗУХ-ийн Хүний нөөц, шагнал хариуцсан ахлах мэргэжилтэн, Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн, Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн, Гадаад харилцаа, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн, СТСХ-ийн Банкны төлбөр тооцоо хариуцсан ахлах мэргэжилтэн, Төсвийн мэргэжилтэн, 1 дүгээр хорооны нийгмийн ажилтан, 2 дугаар хорооны Нийгмийн ажилтны зэрэг 8 ажлын байранд тусгай шалгалт зарлуулахаар АБТ, тавигдах шаардлага, захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн боловч одоогоор тусгай шалгалт зохион байгуулагдаагүй байна. Сул ажлын байрны зарыг дүүргийн bagakhangai.ub.gov.mn сайт дахь "Ил тод байдал" цэсний "Хүний нөөцийн ил тод байдал-Сул ажлын байрны зар" дэд цэсэнд, мөн "Мэдээ мэдээлэл" буланд тус тус байршуулж ажиллав. | 90 |
| 2. | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг нийт албан хаагчдад танилцуулан, хэлтэс хороодод хүргүүлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тайлангийн хугацаанд албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх сахилга хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд ёс зүй, харилцаа хандлага сэдэвт 5 удаагийн сургалтад нийт албан хаагчдыг хамруулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласнаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй үр дүнтэй байна. Албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг тогтмол хийж, цалин урамшууллыг олгон үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд 1 шалгуур үзүүлэлт болгон дүгнэж ажиллав. | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг дээшлүүлэн хүний нөөцийн хөгжлийг хангах, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, хүний нөөцийн менежментийг бүрдүүлэн ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын дотоод журамд заасны дагуу сургалт семинар тогтмол зохион байгуулж, мэргэжилтнүүдийг давтан сургах, чадавхжуулахад анхаарч ажиллав.<br>Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах ажлыг хөтөлбөр, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, энэ ажлын хүрээнд "Төрийн албан хаагчийн сургалт" хөтөлбөр, "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар "Төрийн албан хаагчийн сургалт" хөтөлбөр 97 хувь, "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" 92 хувьтай хэрэгжив.<br>Хөтөлбөрийн биелэлтийг bagakhangai.ub.gov.mn сайтын Ил тод байдал цэсний "Байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээ" дэд цэсэнд байршууллаа. | 70 |
| 4. | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлж байх | Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах боломжийг бүрдүүлэн 2021 онд төрийн захиргааны албан тушаалын ажлын байрны 8 сул орон тоо байгаа бөгөөд тусгай шалгалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн боловч тайлангийн хугацаанд тусгай шалгалт зохион байгуулагдаагүй байна.<br>Тус газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн П.Дэлгэрийг гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн Аж ахуйн тасгийн эрхлэгч, нярваар дэвшүүлэн томилсон.<br>Мөн хороодын Засаг дарга нарын сонгуулийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан хороодын Иргэдийн Нийтийн Хурлаар иргэдийн олонхийн санал авсан Н.Нямзавыг 1 дүгээр хорооны Засаг даргаар, Б.Батзоригийг 2 дугаар хорооны Засаг даргаар тус тус томилов.<br>Мөн албан хаагчдыг чадавхжуулахад анхаарч төрөл бүрийн сургалт, семинар, зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх, нэгнийгээ орлох чадвартай болгоход анхааран ажиллав. | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| 5. | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлж байх | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга байлгах ажлын хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн "Ажилтан, албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх" талаар Тамгын газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8 дугаар бүлэгт 10 зүйл болгон нарийвчлан тусгаж, албан хаагчид үйл ажиллагааныхаа үр дүнг шударгаар үнэлүүлэх боломжийг хангаж өгсөн.<br>Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 22 аж ахуйн нэгж, байгууллагад Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалыг хүргүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан боловсруулах талаар заавар, зөвлөгөөг өгч, 22 байгууллагын төлөвлөгөөг дүүргийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>ЗДТГ-ын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад арга зүйн заавар зөвлөмжийг өгч ажиллав. Журамд заасны дагуу нэгжийн менежер-4, төрийн захиргааны 20, төрийн тусгай 3, төрийн үйлчилгээний-15, гэрээт-8 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө, 5 албан хаагч үр дүнгийн гэрээг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав. Албан хаагчдын 2021 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор авч дүгнэв. Байгууллагын үнэлгээний багийг даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, 2021 оны 12 дугаар сарын 10-ны дотор гүйцэтгэлийн тайланг авч, 51 албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлэн ЗДТГ-ын даргын тушаалаар сарын үндсэн цалингийн 36-40 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал олголоо. | 70 |
| | Үнэлгээний дундаж хувь: | | |
| | Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал | | 78% |
| 1. | 3.1. Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх | Дүүргийн 2022 оны төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулан төсвийн 10 байгууллагын саналыг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн. | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| 2. | 3.2. Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх | Дүүргийн 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл, 2021 оны ИТХ-ын 2020.12.14-ны А/09 тогтоолоор баталсан төсөв, 2021 оны төсөвт тодотгол хийгдэж өөрчлөлт оруулсан ИТХ-ын 2021.10.21-ны А/03 тогтоолуудыг шилэн дансны сайт, байгууллага болон хэлтсийн мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн. | 90 |
| 3. | 3.3. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх | Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2021 оны төслийн эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2020 оны жилийн эцэс, 2021 оны 1, 2, 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэл, 2021 оны оны 1-12 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг shilendans.gov.mn сайт, байгууллагын болон хэлтсийн мэдээллийн самбарт байршуулж иргэд олон нийтийн зүгээс төсвийн зарцуулалтанд хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллалаа. | 90 |
| 4. | 3.4. Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх | Нийслэл дэх Төрийн аудитын газрын шалгалтаар дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгдсэн тайланд "Зөрчилгүй" дүгнэлтийг өгсөн. Аудитын дүгнэлтийг 2021.04.15-ны дотор shilendans.gov.mn сайт, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан. | 90 |
| 5. | 3.5. Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх | Улс, нийслэлийн төсөвт тодотгол хийгдсэнээр дүүргийн төсвийг ИТХ-ын 2021.10.21 –ны А/03 тогтоолоор 6,624.0 сая төгрөгөөр баталсан. Энэхүү тогтоолыг хууль, журмын дагуу цахим сайт болон мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр ханган ажилласан. | 90 |
| | Үнэлгээний дундаж хувь: | | 90% |
| | Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал | | |
| 1. | 4.1. Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх | 2021 оны Засгийн газрын 140 дүгээр тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавин ДИТХ-р батлагдсанаас бусад худалдан авалт хийгдэхгүй байх талаар мэдээ мэдээллийг дүүргийн ААН, Төсөвт байгууллагын нягтлангуудад танилцуулан хяналт тавин ажиллаж байна. | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| 2. | 4.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулан, тогтмол шинэчилж байх | 2021 оны дүүргийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас эхний хагас жилийн байдлаар нийт 15 ажлын үнэлгээний хороо байгуулагдсанаас 2 ажлын тендер шалгаруулалтыг цуцалсан бөгөөд 12 ажлын тендер шалгаруулалтыг цахим системээр зохион байгууллаа. | 90 |
| 3. | 4.3. Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх | 2021 оны дүүргийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас эхний хагас жилийн байдлаар нийт 15 ажлын үнэлгээний хороо зохион байгуулагдаж А3 гэрчилгээтэй 15 иргэнийг оролцуулсан. | 90 |
| 4. | 4.4. Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх | Тендерийн баримт бичиг, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх мэдээллийг мэдээллийн самбартаа байршуулсан бөгөөд www.tender.gov.mn сайтад болон shilendans.gov.mn сайтад тендер шалгаруулалтын үр дүнг байршуулж нийтэд ил тод нээлттэй мэдээлж байна. Хугацаа хоцорч байршуулсан мэдэгдэл байхгүй. | 90 |
| 5. | 4.5. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх | Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар болон Нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж ирсэн тендер шалгаруулалтанд оролцсон компаниудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа , ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан тухай мэдэгдлийг 14 байгууллагад, шалгараагүй мэдэгдлийг 14 байгууллагуудад тус тус хүргүүлж үр дүнг www.tender.gov.mn -д тухай бүр хуулийн хугацаанд нийтэлж олон нийтэд ил тод танилцуулж ажилласан. Мөн www.shilendans.gov.mn сайтад тухай бүр тендер шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээллийг байршуулсан. | 90 |
| 6. | 4.6. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх | 2021 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг сар бүр дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт тухай бүр албан бичгээр явуулдаг ба дүүргийн вэб сайтад тухай бүр байршуулж хэвшсэн. | 90 |
| 7. | 4.7. Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх | 2021 оны худалдан авах ажиллагаанд илэрсэн зөрчил байхгүй болно. | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| 8. | 4.8. Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх | Сургалтанд хамрагдах иргэдийн судалгаа нэгтгэж 3 дугаар сард цахимаар сургалтыг зохион байгуулж нийт 23 албан хаагч, 6 иргэнийг хамруулсан. А3 гэрчилгээ олгох шалгалтыг 2021 .03.18-ны өдөр цахимаар холбогдох дээд шатны байгууллагатай хамтран зохион байгуулж нийт шалгалтанд 29 хүн оролцохоос 2 дугаар хороонд "Ковид19" цар тахал гарсаны улмаас 10 хүнийг шалгалтыг хойшлуулж, 18 иргэн шалгалтанд орж 12 хүн шалгалтанд тэнцсэн. Хойшлогдсон 10 хүний 06 дугаар сарын сүүлийн 7 хоногт шалгалтанд оруулахаар төлөвлөсөн.А3 гэрчилгээтэй 34 албан хаагч, 8 иргэн нийт 42 хүний бүртгэлийг шинэчилсэн. | 90 |
| 9. | 4.9. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх | Нийслэлийн Төрийн аудитын газраас 2020 онд зохион байгуулагдсан хөрөнгө оруулалтын ажилд аудит хийсэн бөгөөд аудитын дүгнэлтийг шилэн дансанд байршуулсан. Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын дүгнэлтийг мөн байршуулсан. | 90 |
| 10. | 4.10. Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх | 2021 он жилийн эцсийн байдлаар тендер шалгаруулалттай холбоотой гомдол ирээгүй болно. | 90 |
| | Үнэлгээний дундаж хувь: | | 90 |
| | ҮНЭЛГЭЭ | | 87% |

Нийт 4 зорилтын 25 заалтыг хяналтад авч, 90 хувийн хэрэгжилттэй 22, 70 хувийн хэрэгжилттэй 2 заалт байгаа бөгөөд 87%-тай хэрэгжив.

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХДЭЛГЭР